



“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү Эрсдэлийн удирдлагын журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Тэнгэрлиг Медиа Групп” ХК (цаашид “Компани” гэх)-ийн зорилго, зорилтуудыг хангахад учирч болох эрсдэлийг таних, хэмжих, түүнд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлж эрсдэлийн нөлөөллийг удирдах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Эрсдэлийг тодорхойлохдоо Компанийн үйл ажиллагаанд өнгөрсөн хугацаанд гарсан эрсдэлүүдийг тодорхойлж, ирээдүйд ямар эрсдэл гарч болох, тэдгээрийн давтамж, цар хүрээг тооцох, цаашид хэрхэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулна.
- 1.3 Компанийн зүгээс бүх шатны менежер болон ажилтнууд бизнесийн үйл ажиллагааны төлөвлөлт болон өдөр тутмын ажлын гүйцэтгэлд учирч болзошгүй бүх төрлийн эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдах талаар мэдээлэлтэй байхыг шаардана.
- 1.4 Компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой дараах үндсэн эрсдэлүүдийг авч үзнэ.
 - 1.4.1 Санхүүгийн эрсдэл;
 - 1.4.2 Үйл ажиллагааны эрсдэл;
 - 1.4.3 Компанийн бичиг баримт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн эрсдэл;
 - 1.4.4 Гадаад хүчин зүйлсийн эрсдэл.

ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭТГЭЭД

- 2.1 Төлөөлөн удирдах зөвлөл (Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо) нь Компанийн гадаад ба дотоод үйл ажиллагааны бүхий л эрсдэл, санхүү, хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад эрсдэлийг эрсдэлийн менежментээр хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна.
- 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Хөрөнгө оруулалт, снахүү, эрсдэлийн хороо нь улирал бүр эрсдэлийн үнэлгээ хийж, хяналт тавих ба хорооны үйл ажиллагааны журамд заасны дагуу холбогдох санал, зөвлөмж гаргаж ТУЗ-д танилцуулна.
- 2.3 Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, Компанийн өдөр тутмын үйл ажиллагаа дах эрсдэлийн удирдлагыг хариуцан хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

- 3.1. Эрсдэлийн удирдлага нь бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдэд тогтмол хяналт тавих замаар иж бүрэн, дэс дараалал бүхий, байнга үргэлжлэх үйл явц байна.
- 3.2. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь дараах үе шатаас бүрдэнэ.
 - 3.1.1 Компанийн үйл ажиллагаа дах эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, эрсдэл нэг бүрийн үндсэн шалтгааныг олж тогтоох, түүнээс гарч болох нөлөө;
 - 3.1.2 Эрсдэлийг хэмжих шалгуурыг тодорхой болгох;
 - 3.1.3 Тогтоосон шалгуурын дагуу эрсдэлийг хэмжих, зэрэглэх;
 - 3.1.4 Зэрэглэлийн дагуу авах хариу арга хэмжээ, хариуцах эздийг тодорхойлох;
 - 3.1.5 Хэрэгжүүлсэн арга хэмжээнд дахин хяналт хийх;
 - 3.1.6 Эрсдэлийг дахин үнэлэх.
- 3.3. Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болох томоохон эрсдэлүүдийг бий болгогч шалтгаануудыг тодорхойлж хяналтын боломжит тогтолцоог эрсдэлийн бүртгэлд тэмдэглэх ба тогтмол хугацаанд байнга шалгаж, сайжруулах шаардлагатай.



- 3.4. Шийдвэр гаргахдаа тухайн эрсдэлийг хүлээнээр илэрч болох эерэг үр дүнтэй зэрэгцүүлэн авч үзэж шийдвэрийг гаргана.
- 3.5. Эрсдэлд дүн шинжилгээ хийснээр Компаниас эдгээр эрсдэлийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлно. Хэрэв тухайн эрсдэлийг хүлээхээр шийдвэрлэсэн бол эрсдэлийг хэрхэн удирдаж болох талаар дараах сонголтуудаас аль нэгийг дангаар нь буюу хамтад нь гаргах боломжтой.
- Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх (эрсдэлийг удирдах ямар нэгэн арга хэмжээ авахгүй)
 - Гуравдагч этгээдэд шилжүүлэх (даатгалд хамруулах, аутсорсинг хийх г.м)
 - Дотоод хяналтын тусламжтайгаар эрсдэлийн магадлал болон нөлөөллийг бууруулах

ДӨРӨВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 4.1 Эрсдэлийн удирдлагын бодлого, түүний хэрэгжилтэд дотоод хяналт, дотоод аудитаас хяналт, аудит хийнэ.
- 4.2 Дотоод аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагын саналд үндэслэн Журамд нэмэлт, өөрчлөлт оруулна.

---oOo---